

20<sup>24</sup> он 05 сар 29 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

**“Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл” авах,  
Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтуудыг тус тус үндэслэн “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

1. “Говь” ХК нь дараах нөхцөлийн дагуу “Голомт Банк”-тай “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл”-н гэрээ байгуулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
  - 1.1. Зээлийн хэмжээ: 10,500,000,000 /арван тэрбум таван зуун сая/ төгрөг
  - 1.2. Зээлийн хугацаа: 12 /арван хоёр/ сар
  - 1.3. Зээлийн хүү:
    - Төгрөгийн хүү жилийн 5.0 /таван/ хувь, эргэн төлөлт хийх хуваарьт өдөр зээлийн төлөлтийг хийгээгүй тохиолдолд түүнээс хойш тооцогдох зээлийн хүүгийн төлбөрт хүүгийн дэмжлэг олгогдохгүй бөгөөд зээлийн хүү 18.0 /арван найман/ хувьд шилжих,
2. “Голомт Банк”-с “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл” авч байгаатай холбоотойгоор “Говь” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК болон “Таван Богд” ХХК, “Улаанбаатар Гурил” ХХК, “Улаанбаатар Принт” ХХК, “Таван Богд Интернэйшнл” ХХК, “Эйрлинк Монголиа” ХХК, “Таван Богд Моторс” ХХК, “Таван Богд Солюшнс” ХХК-иудын хамт тус банктай байгуулсан ЗББГС210207652/GNPLT тоот Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд дараах өөрчлөлтийг оруулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
  - 2.1. Эрхийн хэмжээг 10,500,000,000 /арван тэрбум таван зуун сая/ төгрөг хүртэл буюу түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютаар бууруулах,
  - 2.2. Эрх бууруулах хугацаа: Дээрх “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл” төлөгдөж дуусах хүртэл,
3. “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл” авч байгаатай холбоотой үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №1-д заасан хөрөнгийг барьцаалахыг зөвшөөрсүгэй.
4. ЗББГС210207652/GNPLT тоот Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд нэмэлт өөрчлөлт орж байгаатай холбоотой үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №2-д заасан хөрөнгүүдийг үргэлжлүүлэн барьцаалахыг зөвшөөрсүгэй.
5. Дээрх “Ноолуур бэлтгэлд зориулан олгох зээл”-н гэрээ, барьцааны гэрээ, бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Говь” ХК-ийн Гүйцэтгэх захирал /Б.Амарсайхан/-д, түүнтэй холбогдох Зээлийн багц бүтээгдэхүүний нэмэлт гэрээ, барьцааны гэрээ, батлан даалтын гэрээ болон бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь”

2024 он 05 сар 29 өдөр

Дугаар 25

Улаанбаатар хот

ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Дэд захирал /Э.Пүрэвлхам/-д тус тус олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

Д.ГЭРЭЛМАА

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Б.АМАРСАЙХАН

Ц.БААТАРСАЙХАН

А.ЖАРГАЛМАА

Н.МӨНХБАТ

Ц.ОРГИЛБОЛД

Э.ПҮРЭВЛХАМ

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР

2024 он 05 сар 29 өдөр

Дугаар 26

Улаанбаатар хот


**Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд  
нэмэлт өөрчлөлт оруулах тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 75 дугаар зүйлийн 75.1, 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалтуудыг тус тус үндэслэн “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ** нь:

- “Говь” ХК болон “Таван Богд Холдингс” ХХК, “Таван Богд” ХХК, “Улаанбаатар Гурил” ХХК, “Улаанбаатар Принт” ХХК, “Таван Богд Интернэйшнл” ХХК, “Эйрлинк Монголиа” ХХК, “Таван Богд Моторс” ХХК, “Таван Богд Солюшнс” ХХК-уудын хамт Голомт Банктай байгуулсан 2018 оны 03-р сарын 19-ний өдрийн ЗББГС210207652/GNPLT тоот Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд дараах нэмэлт өөрчлөлт оруулахыг зөвшөөрсүгэй. Үүнд:
  - 1.1. Эрхийн хэмжээг 20,000,000,000 /хорин тэрбум/ төгрөгөөр нэмэгдүүлэн 90,000,000,000 /ерэн тэрбум/ төгрөг хүртэл буюу түүнтэй тэнцэх хэмжээний гадаад валютаас хэтрэхгүй байх болгон өөрчлөх,
  - 1.2. Ам.долларын зээлийн хүүг 9.75 /ес зууны далан таван/ хувь болгон бууруулах,
  - 1.3. Ам.долларын зээлийн шугамыг зөвхөн Говь ХК ашиглах эрхтэй байх,
  - 1.4. Зээлийн шимтгэлийг зээлийн эрхийн өссөн дүнгээс нэг удаа 0.2 /Тэг аравны хоёр/ хувиар төлөх,
- Зээлийн багц бүтээгдэхүүний гэрээнд нэмэлт өөрчлөлт орж байгаатай холбоотой үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар “Говь” ХК-ийн Хавсралт №1-д заасан хөрөнгийг үргэлжлүүлэн барьцаалахыг, Хавсралт №2-д заасан хөрөнгийг нэмж барьцаалахыг зөвшөөрсүгэй.
- Дээрх Зээлийн багц бүтээгдэхүүний нэмэлт гэрээ, барьцааны гэрээ, батлан даалтын гэрээ болон бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг “Таван Богд Холдингс” ХХК-ийн Дэд захирал /Э.Пүрэвлхам/-д олгосугай.

ТУЗ-ИЙН ДАРГА:

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



*[Signature]*

Д.ГЭРЭЛМАА

*[Signature]*

Б.АМАРСАЙХАН

*[Signature]*

Ц.УЛААНБААТАРСАЙХАН

*[Signature]*

А.ЖАРГАЛМАА

*[Signature]*

Н.МӨНХБАТ

20<sup>24</sup> он 05 сар 29 өдөр

Дугаар 026

Улаанбаатар хот


Ц.ОРГИЛБОЛД

Э.ПҮРЭВЛХАМ

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР